

**СҮХБААТАР АЙМГИЙН ДАРЬГАНГА СУМЫН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**

10 дугаар сарын мэдээлэл

2021.10.24.

Нэг. ТӨРИЙН УДИРДЛАГЫН ЧИГЛЭЛЭЭР.

1. Аймгийн ИТХ-ын ХШҮ-ний баг суманд ажиллаж “Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх салбар зөвлөл”-ийн болон бусад чиглэлээрх үйл ажиллагаатай танилцаж, зөвлөгөө зөвлөмж өгч ажиллалаа.
2. Сумын ИТХ-ын ажлын албанаас ИТХ-ын, ЗДТГ-ын ажилтан албан хаагчдад цар тахлын нөхцөлтэй холбогдуулан дархлаа дэмжиж 200000 төгрөгийн витаминжуулалт хийлээ.
3. Сумын ЗДТГ-ын даргын тушаалаар Тамгын газрын 8 өрөөнд мананцар үүсгэгч авч байршуулан ковидын үеийн ариутгал халдваргүйтгэлийг зохион байгууллаа.
4. Аймгийн Засаг даргын захирамжийн хэрэгжилтийг хангаж сумын Засаг даргын 2021 оны 10 дугаар сарын 01 ний өдрийн А/107 дугаар захирамжаар томилогдсон ажлын хэсэг “Цэрэг татлагын ажил”-ыг зохион байгуулж, үзлэгт суманд 29, аймагт 22 нийт 51 хүнийг хамруулснаар ковид туссан 8 хүнийг чөлөөлөх, ар гэрийн гачигдал хүндэтгэх нөхцлөөр 3 иргэнийг чөлөөлөх арга хэмжээг авлаа.
5. Аймгийн Шуурхай штабын цахим хуралд оролцож, ЭМС-ын 2021 оны А/214 дүгээр тушаалын дагуу “Цогцос оршуулах түр журам”-ыг хэрэгжүүлэхээр сумын Засаг даргын захирамжаар “Оршуулгын үйл ажиллагаанд хяналт тавих” дэд бүлгийг сумын Засаг даргын орлогчоор ахлуулан томиллоо.
6. Аймгийн МХГ-ын төлөвлөгөөт шалгалтаар 11 хүний бүрэлдэхүүнтэй баг суманд ажиллаж зөвлөн туслах үйлчилгээ үзүүлсэн.
7. Аймгийн Засаг даргын 2021.10.14 ний А/594 дүгээр захирамжийг хэрэгжүүлж “Бэрх биш ээлтэй” аяныг зохион байгуулахаар төлөвлөгөө удирдамжийг боловсруулаад ажиллаж байна.
8. Монголын Ахмадын болон Багш нарын өдрүүдийг тохиолдуулан багш, ажилчид, ахмад настнуудад хүндэтгэл үзүүлсэн.

Хоёр. ХӨДӨӨ АЖ АХУЙН болон ТӨВ СУУРИНГИЙН өвөлжилт, газрын харилцааны ЧИГЛЭЛЭЭР.

1. Зудын эрсдлийн үнэлгээ хийх ажлын хүрээнд мэдээлэл авах хүснэгтийн дагуу судалгааг хийж дунд эрсдэлтэй гэсэн үнэлгээтэй байна.
2. Тус сумын “Дарьганга тохижилт үйлчилгээ” ОНӨААТҮГазар нь сумын нэгдсэн халаалтыг 2021.10.01 ний өдрөөс өгч эхэлсэн бөгөөд одоогоор 13 орон тоотой ажиллаж байгаа, мөн 150,6 тн нүүрс татаж 35 тн-ны нөөцтэй байна. Тус байгууллага нь нүүрсний гэрээг “Тал булаг” ХХК-тай, тээвэрлэлтийн гэрээг “Нарт Баянгол” ХХК-тай тус тус байгуулаад ажиллаж байна.
3. “Газар нутгийн нэрийн тодруулалтын ажил”-ыг зохион байгуулах ажлын хэсэг 4 хүний бүрэлдэхүүнтэй 7 хоног суманд ажиллаж одоогоор 10 шинэ нэршлийг тодруулаад ажиллаж байна. Иргэд цахимаар (egazar.gov.mn) хаягаас газрын харилцааны үйлчилгээг авах бүрэн боломжтой болсон талаар мэдээллийг 95 хүнд хүргээд байна.
4. “Баян намар-2021” үзэсгэлэн худалдааг зохион байгуулах ажлын хэсэг болон зардлын асуудлыг сумын Засаг даргын 2021 оны А/115 дугаар захирамжаар шийдвэрлэн 1005000 (нэг сая таван мянган) төгрөгийн шагналын сантайгаар 5(Шилдгийн шилдэг, “Дарьганга брэнд бүтээгдэхүүн, Сүү-сүүн бүтээгдэхүүн, Хүнсний ногоо, Хоол үйлдвэрлэл) номинациар зохион байгууллаа.

Гурав. БОЛОВСРОЛ, СОЁЛ УРЛАГИЙН ЧИГЛЭЛЭЭР

- Боловсролын үнэлгээний төвөөс зохион байгуулж буй ЕБС-ийн сурагчдын эзэмшвэл зохих агуулгын хоцрогдлыг тодорхойлох "Оношлох үнэлгээ"-ний сорил, санал асуулганд дунд, ахлах ангийн 113 сурагч, 6-12 дугаар ангийн 23 эцэг эх хамрагдсан.

- **“Дэлхийн сурагчдын сүүний өдөр”** Нэгдсэн үндэсний байгууллагын ХХААБ-аас санаачлан 2000 оноос Дэлхийн нийтээр жил бүрийн 9 сарын сүүлийн лхагва гарагт тэмдэглэдэг энэхүү өдөрт нэгдэн “Нэг аяга сүү-Нэг насны дархлаа” уриан дор аян өрнүүлж, хүүхэд бүрийг нэг удаа дархлааг дэмжих зорилгоор хамт олноор нэгдэн багш ажилчдын зүгээс 54 литр сүү бэлтгэн дунд болон ахлах ангийн 264 хүүхдэд хичээлийн завсарлагаар зөгийн балтай бүлээн сүү уулгаж, хүний эрүүл мэндэд сүү цагаан идээ ямар ашиг тустай талаар мэдээлэл хийсэн.

- 2021 оны 10 сарын 13 нд Сургуулийн тэтгэлэгт хөтөлбөрийн 5 дугаар шатанд тэнцэж гэрээ байгуулсан. “Боловсролын чанарын шинэчлэл” төслийн хүрээнд **"Оюуныг түгээгч отрын багш"** 10,384,200 / арван сая гурван зуун наян дөрвөн мянга хоёр зуу / төгрөгийн санхүүжүүлт бүхий тэтгэлгийг хэрэгжүүлэхээр болсон.

- Монголын багш нарын 55 дахь баярын өдөрт зориулан “Сурагч нэг өдөр” арга хэмжээг 10 дугаар сарын 04-ний өдөр зохион байгуулсан. Нийт 35 сурагч багш болсон. Энэ өдөр хичээл, сургалтын үйл ажиллагааг суралцагч нар маш сайн зохион байгуулж ажилласан. Мөн Залуу багш нар, сурагчдын зөвлөл хамтран багш нартаа сэтгэлийн бэлэг барьж, ахмад багш нарт хүндэтгэл үзүүллээ.

Дөрөв. ЭРҮҮЛ МЭНДИЙН ЧИГЛЭЛЭЭР

- КОВИД-19 цар тахлын нөхцөл байдлын мэдээгээр: гэрийн эмчилгээнд 2021.10.23 ны байдлаар 66 иргэн, ойрын хавьталд 168 нийт 234 иргэн хяналтад байна.
 - 2021.10.23 ны өдрийн Аймгийн Шуурхай штабын цахим хуралд сумын ОК-ын дарга, ЭМТ-ийн дарга, Тамгын газрын дарга нар оролцлоо. Хурлаас ойрын үед а/. Цар тахлаас урьдчилан сэргийлэх 3 дугаар
 - тунгийн тарилгыг идэвхжүүлэх аяныг өрнүүлж, 11 р сарын 10 ны байдлаар хамрагдалтын хувийг 70 % д хүргэх зорилт тавьж ажиллах. б/. Хүнд өвчтнийг тээвэрлэх тоноглогдсон машиныг бэлэн байлгах, үгүй бол АНЭ-тэй хамтран ажиллах.
- в/. Хүчилтөрөгч өтгөрүүлэгчийн тоог нэмэгдүүлэх арга хэмжээ авах зэрэг үүргийг өгсний дагуу сумын Онцгой комисс анхааралдаа авч үйл ажиллагааг эрчимжүүлж байна.

- **Цахим орчинд :** 1/. Дэлхийн гар угаах өдөр, 2.Ковид-19 өөр өвдөөд эдгэрсэн хүмүүст өгөх хоолны зөвлөмж, 3. Ковид-19 –ийн халдвар авсан хүмүүсийн гэрийн арчилгаа, сувилгаа, 4. Ахмад настны хооллолт, дасгал хөдөлгөөн, сэтгэл зүй, 5. Аюулгүй сонголт хийхэд туслах 3 хүчин зүйлс, 6. Түргэвчилсэн шинжилгээ өгөх цагийн хуваарь, зөвлөмж, 7. Дельта хувилбараас сэргийлье . 8. Вакцины 3 дугаар тундаа хамрагдахыг уриалсан зэрэг мэдээлэл оруулахад 41 хүний хандалтыг авсан бол Улаан бүсэд ажиллаж буй эмнэлгийн ажилчдын нөхцөл байдлын талаар 4 удаа мэдээлэл оруулахад 307 хандалтыг авсан байна.

Тав. Байгаль орчны чиглэлээр:

1. Аймаг, сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн холбогдох заалтыг хэрэгжүүлэх зорилгоор аялал жуулчлалын чиглэлээр эвент арга хэмжээг уламжлал болгон зохион байгуулах зорилготой **“Хунгийн баяр-2021”** арга хэмжээг сумын БЦГХЗ-тай хамтран зохион байгуулж, нийт 3 сая төгрөгийн шагналын сангаас 1,5 сая төгрөгийг сумын Засаг даргын нөөц сангаас гаргаж **“Дарьгангын намар”** фото зургийн үзэсгэлэн худалдааны шагналд зарцууллаа.

2. Нийтийн их цэвэрлэгээний ажлыг зохион байгууллаа.

НИЙГМИЙН ХАЛАМЖ, ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ЧИГЛЭЛЭЭР

Хөдөлмөр халамжийн үйлчилгээний чиглэлээр “Дарьганга овооны эзэд” ТББ-ын хоёр ажилтан суманд хоёр хоног ажиллаж “Ажилгүй иргэдэд ажил мэргэжлийн баримжаа олгох нь” сэдэвт сургалтыг зохион байгуулж 16 ажилгүй иргэн оролцож, нэг иргэнийг төсөл хөтөлбөрт хамруулахаар шийдвэрлэв.

МЭДЭЭ НЭГТГЭСЭН
МЭРГЭЖИЛТЭН Д. МӨНХЗУЛ

ХЯНАСАН
СУМЫН ЗАСАГ ДАРГА Д. БОЛДБААТАР